

**"Даланзадгадын дулааны цахилгаан станц" ТӨХК-ны 2015 оны 2-р улирлын тайлан
үйл ажиллагааны тайлан**

Нэг. Техник эдийн засгийн үзүүлэлтийн талаар

"Даланзадгадын дулааны цахилгаан станц" ТӨХК нь 2015 оны 2-р улиралд 3.9 сая кВт.ц ЦЭХ боловсруулж, 1.3 мян кВт.ц ЦЭХ-ийг түгээсэн нь өмнөх оноос 62.8% буюу 829.6 мян.кВт.ц-аар, төлөвлөлтөөс 30.7% буюу 314.9 мян.кВт.ц-аар өссөн байна. Харин ДЭХ-ний хувьд 14.0 мян.Гкал-г түгээсэн нь урьд оны гүйцэтгэлээс 21.7 хувиар буюу 2.5 мян.Гкал-аар, төлөвлөлтөөс 10.7 хувиар буюу 1.3 мян.Гкал-аар тус тус өссөн байна.

Техник эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Урьд оны мөн үеийн гүйцэтгэл	2015 он 2-р улирал		Өөрчлөлт		
			Төлөв	Гүйцэтгэл	Өм.оноос	Төл-өөс	
Нийт боловсруулалт	мян.кВтц	2,246.7	3,550.2	3,851.6	1,604.9	301.4	
ДХЦЭХ	Станц	мян.кВтц	1,737.2	2,526.0	2,512.5	775.3	(13.5)
	Хувь	хувиар	77.3	71.2	65.2	(12.09)	(5.92)
Цахилгаан түгээлт	мян.кВтц	509.5	1,024.2	1,339.1	829.58	314.93	
Түгээсэн ДЭХ	Гкал	11.5	12.6	14.0	2.5	1.3	
Усаар	Гкал	11.5	12.6	14.0	2.5	1.3	
Уураар	Гкал	-	-	-	-	-	
Жишмэл түлшний хувийн зарцуулалт ЦЭХ	Цахилгаан	гр/кВт.ц	1,597.0	1,650.0	1,618.0	21.0	(32.0)
	Дулаан	кг/Гкал	790.7	530.0	576.7	(214.1)	46.7
Нүүрсний бодит зарцуулалт	Цахилгаан	тонн	1,077.9	2,274.9	2,742.0	1,664.2	467.2
	Дулаан	тонн	12,033.3	9,013.9	10,202.4	(1,830.9)	1,189
Нүүрсний илчлэг		ккал/кг	5,284.8	5,200.0	5,531.2	246.4	331.2



2015 оны 2-р улиралд нийт боловсруулсан ЦЭХ-нээс дотоод хэрэгцээндээ 65.2%-ийг зарцуулсан нь төлөвлөлтөөс 5.9 нэгжээр, өмнөх оноос 12.1 нэгжээр буурсан байна. Дотоод хэрэгцээний ЦЭХ урьд онуудтай харьцуулахад өсч байгаа нь 2 зуух 1 турбины горимд ажиллан ДЭХ-ний үйлдвэрлэлээ түлхүү анхаарч, түүний хажуугаар нь бага хэрэглээтэй Хүрмэн, Жуулчин фидерийг ЦЭХ ээр хангах бодлого барьж ажилласантай холбоотой.

Жишмэл түлшний хувийн зарцуулалтыг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзвэл цахилгаанд 21 гр/кВт.ц-аар өссөн, дулаанд 214.1 кг/Гкал-аар буурсан, төлөвлөгөөнөөс цахилгаанд 32 гр/кВт.ц-аар буурсан, дулаанд 46.7 кг/Гкал-аар өссөн байна. Нэгж дулаан эрчим хүчинд ноогдох жишмэл түлшний хувийн зарцуулалт төлөвлөлтөөс өссөн нь 2-р сард шинэ Даланзадгадын хэрэглээг ДЭХ ээр ханган ажиллахад шаардагдах бэлтгэл ажилд уурын зарцуулалт нэмэгдсэнтэй холбоотой.

Хоёр. Санхүү, эдийн засгийн үзүүлэлтийн талаар

2015 оны 2-р улирлын байдлаар нийт 1042.3 сая төгрөгийн борлуулалт хийж, улсын төсвөөс 300.0 сая төгрөгийн татаас авч, үйл ажиллагаандаа 2262.0 сая төгрөгийн зардал гаргаж, алдагдал нөхөх татаасыг оруулж тооцвол 919.6 сая төгрөгийн үйл ажиллагааны алдагдалтай ажилласан. Үйл ажиллагааны бус 186.4 сая төгрөгийн орлого олж, 51.1 сая төгрөгийн зардал гарган 784.3 сая төгрөгийн балансын алдагдалтай ажиллажээ.



Өмнөх оны мөн үетэй харьцуулбал үйл ажиллагааны алдагдал татаасгүй дүнгээр 356.9 сая төгрөгөөр, балансын алдагдал 152.8 сая төгрөгөөр буурсан, төлөвлөгөөтэй харьцуулвал үйл ажиллагааны алдагдал татаасгүй дүнгээр 285.1 сая төгрөгөөр буурсан, балансын алдагдал 57.5 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.


Балансын алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 152.8 сая төгрөгөөр буурсан нь нийт зардал 58.7 сая төгрөгөөр, орлого 211.5 сая төгрөгөөр өссөний зөрүү юм. Харин төлөвлөлтөөс 57.5 сая төгрөгөөр өссөн нь нийт зардал 24.9 сая төгрөгөөр буурч, орлого 82.4 сая төгрөгөөр буурсны зөрүү юм.

Санхүү, эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлтүүд	Нэгж	Мөн үеийн гүйц	2015 он		Өөрчлөлт	
			Төлөв	Гүйцэтгэл	Өм.он-с	Төл-өөс
Нийт орлого	сая.төг	1,317.2	1,611.1	1,528.7	211.5	(82.4)
Үйл ажиллагааны орлого	сая.төг	1,151.2	1,484.9	1,342.3	191.1	(142.5)
Цахилгааны орлого	сая.төг	21.4	37.3	71.3	49.9	34.0
Дулааны орлого	сая.төг	629.8	747.6	971.1	341.2	223.5
Татаасын орлого	сая.төг	500.0	700.0	300.0	(200.0)	(400.0)
Үйл ажиллагааны бус орлого	сая.төг	166.0	126.2	186.4	20.4	60.2
Нийт зардал	сая.төг	2,254.4	2,337.9	2,313.1	58.7	(24.9)
Үйл ажиллагааны зардал	сая.төг	2,227.7	2,289.6	2,262.0	34.3	(27.6)
Цахилгааны зардал	сая.төг	183.1	461.4	479.2	296.0	17.8
Дулаан зардал	сая.төг	2,044.6	1,828.2	1,782.8	(261.8)	(45.4)
Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	26.6	48.3	51.1	24.4	2.7
Үйл ажиллагааны ашиг, алдагдал	сая.төг	(1,076.5)	(804.7)	(919.6)	(156.9)	114.9
Үйл ажилланы ашиг, алдагдал /татаасгүй/	сая.төг	(1,576.5)	(1,504.7)	(1,219.6)	(356.9)	(285.1)
Балансын ашиг, алдагдал	сая.төг	(937.1)	(726.8)	(784.3)	(152.8)	57.5

Борлуулалтын орлого

ЦЭХ-ний борлуулалтын орлого өмнөх оны гүйцэтгэлээс 49.9 сая төгрөгөөр, ДЭХ-ний борлуулалтын орлого 341.2 сая төгрөгөөр тус тус өссөн. Энэ нь ЭХЗХорооноос тарифыг нэмэгдүүлж, 2014 оны 10 сарын 5-нд ААНБ-ыг 2%-иар, Айл өрхийг 14%-иар, 12 сарын 1-нд ААНБ-ыг 13%-иар, Айл өрхийг 15%-иар тус тус нэмэгдүүлсэнтэй холбоотой. Төлөвлөгөөтэй харьцуулбал ЦЭХ-ний борлуулалтын орлого 34.0 сая төгрөгөөр, ДЭХ-ний орлого 223.5 сая төгрөгөөр өссөн байгаа нь станцын хэвийн ажиллагаатай мөн ДЭХ-ний хэрэглэгчийн өсөлттэй холбоотой.



Үйл ажиллагааны бус орлоор нийт 186.4 сая төгрөг орж ирсэнд:

- "Энержи ресурс" ХХК-аас хандив 89.9 сая төгрөг
- * Үйлчилгээний хөлсний орлогоос 8.8 сая төгрөг
- * Хүү, торгууль, валютын ханшийн зөрүүгийн орлогоос 2.1 сая төгрөг
- * Материал борлуулсны орлогоос 0.5 сая төгрөг
- * Хоолны хөнгөлөлтийн зөрүүгээс 9.8 сая төгрөг
- * Бусад төрлийн орлогоор 75.2 сая төгрөгийн орлого тус тус нэмэгдэж орсон байна. /үүнд: ДЦС-ний засвар үйлчилгээний ажил хийж гүйцэтгэсэний орлого орсон/

Зардлын талаар

2015 оны 2-р улирлын байдлаар үйл ажиллагааны зардал өмнөх оны гүйцэтгэлээс 34.2 сая төгрөгөөр өссөн, төлөвлөснөөс 27.6 сая төгрөгөөр буурсан байна. Нийт зардал өмнөх оноос 58.7 сая төгрөгөөр өссөн, төлөвлөснөөс 24.9 сая төгрөгөөр буурсан байна.

№	Үзүүлэлтүүд	Нэгж	2014 оны мөн үе	2015 он		Эзлэх хувь	Өөрчлөлт		
				Төлөв	Гүйцэтгэл		Өмнөх оноос	Төл-өөс	
1	Түлшний зардал	сая.төг	248.5	190.9	260.1	11%	11.6	69.2	
2	Сэлбэг, материалын ардал	сая.төг	145.5	224.1	128.7	6%	(16.8)	(95.3)	
3	Ашиглалтын зардал	сая.төг	52.9	54.8	74.1	3%	21.2	19.3	
4	Цалин, шимтгэлийн зардал	сая.төг	756.6	834.4	837.1	36%	80.5	2.7	
5	Элэгдлийн зардал	сая.төг	615.9	630.1	611.5	26%	(4.4)	(18.7)	
6	Удирдлагын зардал	сая.төг	59.6	75.2	77.5	3%	17.8	2.3	
7	Борлуулалт маркетингийн зардал	сая.төг	216.6	150.4	155.7	7%	(61.0)	5.2	
8	Ажиллагсдын нийгмийн зардал	сая.төг	13.1	35.8	12.6	1%	(0.5)	(23.2)	
9	УХЗ-ийн хүүгийн зардал	сая.төг	58.4	47.8	60.4	3%	2.0	12.5	
10	ҮА-ны бусад зардал	сая.төг	60.5	46.0	44.3	2%	(16.2)	(1.7)	
11	ҮА-ны бус зардал	сая.төг	26.6	48.3	51.1	2%	24.4	2.7	
Нийт дүн			сая.төг	2,254.4	2,337.9	2,313.1	100%	58.7	(24.9)

Нийт зардалд нөлөөлсөн хүчин зүйл

Сөрөг нөлөөлөл /төлөвлөснөөс/:

Түлшний зардал 69.2 сая төгрөгөөр өссөн нь үйлдвэрлэл өссөнтэй холбоотойгоор нүүрсний зарцуулалт 3899 тн-оор нэмэгдэж нүүрсний зардал өссөн.

* Цахилгааны зардал 19.5 сая төгрөгөөр өссөн нь энэ нь цахилгааны 1 квтц-ны 113 төгрөг байснаас 124.2 төгрөг болж 11.2 төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой. Мөн 5 сарын хэрэглээтэй холбоотой.


* Зээлийн хүүгийн зардал 12.5 сая төгрөгөөр өссөн нь Сангийн яамтай хийсэн гэрээнд өөрчлөлт орохгүйгээр ДБТЗээл түүний хүүг манай компани хариуцах болсонтой холбоотой.

Эерэг нөлөөлөл /төлөвлөснөөс/:

- Сэлбэг материалын зардал 95.3 сая төгрөгөөр хэмнэсэн
- Ажиллагсдын нийгмийн зардал 23.2 сая төгрөгөөр хэмнэсэн.

Нэгжийн ашиг, алдагдал

ЦЭХ-ний нэгжийн алдагдал /төг.мөн/



ДЭХ-ний нэгжийн алдагдал /мян.төг/



Авлага, өглөгийн талаар

2015 оны 2-р улирлын байдлаар нийт 345.8 сая төгрөгийн авлагатай гарч оны эхэнд байснаас 128.2%-иар буюу 194.3 сая төгрөгөөр өссөн байна.



Авлагын бүтцээс харахад нийт авлагын 74%-ийг эрчим хүчнээс, 23%-ийг харилцагчдаас, 2%-ийг бусад авлага тус тус эзэлж байна. Авлагын өсөлтөнд аж ахуйн харилцааны авлага 29.6 сая төгрөгөөр, эрчим хүчний авлага 162.7 сая төгрөгөөр, бусад авлага 2.0 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Эрчим хүчний авлага өссөн нь эдийн засгийн хямралаас болоод ҮААН, айл өрхийн хэрэглэгч нар дулааны төлбөрөө өгч чадахгүй байгаатай холбоотой.



Богино хугацаат өглөг 2482.2 сая төгрөг байгаа нь оны эхэнд байсантай харьцуулахад 376.8 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Өглөгийн өсөлт нь аж ахуйн харилцааны өглөг 11.9 сая төгрөгөөр буурсан, тээврийн хөлсний өглөг 31.8 сая төгрөгөөр өссөн, эрчим хүчний өглөг 2.5 сая төгрөгөөр буурсан, бусад өглөг 96.3 сая төгрөгөөр өссөн, татвар шимтгэлийн өглөг 202.8 сая төгрөгөөр өссөн, зээлийн хүүгийн өглөг хуваарийн дагуу 60.4 сая төгрөгөөр өссөн зэрэгтэй холбоотой. ДЭХ-ний бичилтийн орлого дутуу төвлөрч байгаагаас мөн алдагдал нөхөх санхүүжилт хуваарийн дагуу орж ирэхгүй байгаагаас хөрөнгийн дутагдалд орж төсөвт төлөх өр төлбөр, нийлүүлэгч нарт өгөх өр төлбөр нэмэгдэж байна.